



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 72 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвөөр санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж, баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яам болон аудитад хамрагдсан төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэхийг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-эрдэнэ), Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-д даалгасугай.

3. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, танилцуулга хийх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН СЭДЭВ: : “УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСВИЙН ХУУЛЬД ТУСГАЖ БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭМЭГДЭЛ ЗАРДАЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ”

АУДИТЫН КОД: ГНАГ-2023/15-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Д.Энхболд
Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn
Аудитын менежер Н.Анхбаяр
Цахим хаяг: ankhbayarn@audit.gov.mn
Аудитын менежер Ю.Энхтуяа
Цахим хаяг: enkhtuyayu@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	3
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ.....	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ.....	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ.....	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	7-9
ИЛРҮҮЛЭЛТ	10-32
ДҮГНЭЛТ	33
ЗӨВЛӨМЖ	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
БНБД	Барилгын норм ба дүрэм
БХТ	Барилгын хөгжлийн төв
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БУА	Барилга угсралтын ажил
ЗТХТ	Зам тээврийн хөгжлийн төв
ЭХҮТ	Эрчим хүчний үндэсний төв
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
МХС	Мэдээлэл холбоо сүлжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТТХ	Төсвийн тухай хууль
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
УБДС	Улаанбаатар Дулааны Сүлжээ
УСУГ	Ус Сувгийн Удирдах газар
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал, хариуцлагатай компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	БХТ, ЗТХТ, ЭХҮТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг	21
Хүснэгт 2	БХТ-өөс 2020, 2022 онд сонгон шалгаруулж, эрх олгосон эксперт	23
Хүснэгт 3	ЗТХТ-өөс 2022, 2023 онд сонгон шалгаруулж, төсөвт магадлал хийх эрх олгосон эксперт	24
Хүснэгт 4	Салбарын хуулиудад дараах ажлуудад магадлал хийхээр тусгасан байна	25
Хүснэгт 5	Төсөвт ажлын тоо хэмжээ орхигдуулснаас үүдсэн төсөвт өртгийн нэмэлтийг харьцуулсан жишээ	30
Хүснэгт 6	Хаалганы үнэ /2022 оны 4 дүгээр сарын байдлаар/	31

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Сангийн яамнаас ирүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалтын мэдээлэл	7
Дүрслэл 2	Төсвийн ерөнхийлөн захирагчдын мэдээлэл	8
Дүрслэл 3	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тоо /төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр/	9
Дүрслэл 4	Төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааны зураглал	10
Дүрслэл 5	Төсөвт өртөг нэмэгдсэн шалтгааныг багцалсан байдал	12
Дүрслэл 6	Төсөвт өртөгт нэмэгдэл үүссэн явцын зураглал	15
Дүрслэл 7	Олон жил үргэлжилж буй төсөл арга хэмжээний жагсаалт	18
Дүрслэл 8	БХТ, ЗТХТ, ЭХҮТ-ийн 2019-2023 оны хооронд баталгаажуулсан МЕД	22
Дүрслэл 9	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, норматив	29
Дүрслэл 10	Барилга байгууламжийн төсөвт өртгийн задаргаа	32

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуульд тусгаж баталсан 323 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардлын шалтгаан нөхцөлийг тодруулж, дүн шинжилгээ хийн, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа зарим барилга байгууламжийн төсөвт өртгийн нэмэгдүүлсэн шалтгаан үндэслэлтэй эсэх;
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа зарим барилга байгууламжийн төсөвт өртгийн нэмэгдэл нь Монгол Улсын хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй өртөг нэмэгдсэн 323 төсөл арга, хэмжээг хэрэгжүүлж байгаа Төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төв, Зам, тээврийн хөгжлийн төв, холбогдох бусад байгууллага, тендерийн баримт бичиг, батлагдсан зураг, төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт болон бусад холбогдох баримт материалыг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, асуудлын шинжилгээг баримтлан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

Монгол Улсын 2010-2023 оны төсвийн тухай хуулиуд;
Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;

Төсвийн тухай хууль;
Төрийн хэмнэлтийн тухай хууль;
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
Барилгын тухай хууль;
Эрчим хүчний тухай хууль;
Авто замын тухай хууль;
Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”;
Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Н.Анхбаяр үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ю.Энхтуяа, С.Одонцэцэг, аудитор Ж.Оюунтуяа, Б.Булган, Б.Буянхишиг, М.Баяртогтох, Б.Золбаяр, Б.Ууганбилэг, Б.Идэрбалжинням, Д.Нямжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл, бэрхшээл

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдал, барилга угсралтын ажлын чанарт хяналт хийхэд цаг хугацааны нөөц хязгаарлагдмал байсан учир зөвхөн цаасан нотлох баримтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Мөн зарим төсөл, арга хэмжээний захиалагчдаас нотлох баримт ирүүлэх үйл явц удаашралтай, олон жил үргэлжилсэн төсөл, арга хэмжээний баримт материал дутуу байх зэрэг хүндрэл, бэрхшээл байв.

Аудитын төлөвлөгөөнд 128 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргахаар тусгасан боловч, Сангийн яамнаас 14 удаагийн албан бичгээр 530 төсөл, арга хэмжээний жагсаалт ирүүлсэн, эдгээрээс зарим нь давхардсан, зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртөг дахин нэмэгдэж магадлалаар баталгаажиг ирснээс тайланд өөрчлөлт орсон зэрэг нь аудитыг гүйцэтгэх цаг хугацаа хязгаарлагдмал байх хүндрэл бэрхшээлийг үүсгэж байв.

Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт, төсөвт өртөгт хөндлөнгийн мэргэжлийн шинжээчээр дүгнэлт гаргуулан, үр дүнг аудитын дүгнэлтэд ашиглалаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудитад хамруулахаар төсөвт өртөг нь нэмэгдсэн 530 төсөл, арга хэмжээний жагсаалтыг Сангийн яамнаас 1 дүгээр сарын 13-аас 11 дүгээр сарын 10-ны хооронд 14 удаагийн албан бичгээр ирүүлснээс 60 төсөл, арга хэмжээ давхардаж, нийт 3,228,441.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 470 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,541,479.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал ирсэн ба үүнээс 142 төсөл, арга хэмжээний 545,956.1 сая төгрөгийн нэмэгдэл зардал нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд батлагдсан байна.

Нэгдсэн тайланд тусгагдаж байгаа 1,617,352.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 313 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 823,514.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг Сангийн яам буюу захиалагчаас ирүүлснийг 120,222.0 сая төгрөгөөр бууруулж 703,292.8 сая төгрөгөөр баталгаажуулсан.

Үүнээс 34 төсөл, арга хэмжээний нэмэгдэл зардлын санал нь 50,500.2 сая төгрөгөөр өсөж, 76 нь ирсэн саналын дүнгээр, 203 төсөл, арга хэмжээний нэмэгдэл зардлын саналыг 170,722.2 сая төгрөгөөр бууруулсан байна. Мөн нууцад хамаарах 10 төсөл, арга хэмжээний 8 тайлан дүгнэлтийг холбогдох журмын дагуу хүргүүлсэн.

Тус 313 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг холбогдох байгууллагуудын магадлалын дүгнэлтээр 2,560,132.5 сая төгрөгөөр баталгаажуулсныг аудитаар 1,386,943.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 275 төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлтийн дүнг 77,483.3 сая төгрөгөөр бууруулсан.

Дүрслэл 1. Сангийн яамнаас ирүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалтын мэдээлэл

САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТЫН МЭДЭЭЛЭЛ

ДАВХАРДСАН ТООГООР НИЙТ **530** ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭМЭГДЭЛ
ЗАРДАЛД ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХААР САНАЛ ИРҮҮЛСЭН



Дүрслэл 2. Төсвийн ерөнхийлөн захирагчдын мэдээлэл

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

9

СОЁЛЫН
САЙД - 22 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 146,634.50 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 194,340.16 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 47,705.66 сая.төг

1

БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН
САЙД - 3 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 9,105.00 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 10,484.43 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 1,379.43 сая.төг

- Батлагдсан төсөвт өртөг - 8,495.65 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 10,166.95 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 1,671.30 сая.төг

УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР - 2 TAX

10

- Батлагдсан төсөвт өртөг - 180,811.01 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 258,450.77 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 77,639.76 сая.төг

БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
САЙД - 34 TAX

2

11

ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН
САЙД - 7 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 9,871.60 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 14,376.37 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 4,504.78 сая.төг

3

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД - 153 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 545,129.08 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 784,991.91 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 239,862.83 сая.төг

- Батлагдсан төсөвт өртөг - 60,726.50 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 178,469.01 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 117,742.51 сая.төг

ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН
САЙД - 9 TAX

12

- Батлагдсан төсөвт өртөг - 273,066.70 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 356,398.97 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 83,332.27 сая.төг

ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН
САЙД - 9 TAX

4

13

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН
САЙД - 15 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 66,486.76 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 96,573.49 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 30,086.73 сая.төг

5

МОНГОЛ УЛСЫН
САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА - 6 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 10,521.70 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 15,169.66 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 4,647.96 сая.төг

- Батлагдсан төсөвт өртөг - 85,627.90 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 114,038.51 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 28,410.61 сая.төг

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД - 31 TAX

14

- Батлагдсан төсөвт өртөг - 87,691.10 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 110,426.22 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 22,735.12 сая.төг

МОНГОЛ УЛСЫН
САЙД, ОЛИМП,
НИЙТИЙН БИЕЙН
ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА -
12 TAX

6

15

ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЙД - 8 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 107,260.14 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 316,953.72 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 209,693.58 сая.төг

7

МОНГОЛ
УЛСЫН ШАДАР
САЙД - 1 TAX

- Батлагдсан төсөвт өртөг - 4,400.00 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 12,461.19 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 8,061.19 сая.төг

- Батлагдсан төсөвт өртөг - 30,020.30 сая.төг
- Нийт төсөвт өртөг /аудит/ - 19,514.81 сая.төг
- Төсөвт өртгийн өсөлт - 10,505.49 сая.төг

САНГИЙН
САЙД - 3 TAX

8


Дүрслэл 3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тоо /төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр/



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО /ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БҮРЭЭР/

НИЙТ 313 ТАХ-НИЙ НЭМЭГДЭЛ ЗАРДАЛД ДҮГНЭЛТ ГАРГАСАН БӨГӨӨД МУЕА-ЫН ТУШААЛААР БАТЛАГДАЖ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ ХҮРГҮҮЛСЭН. ҮҮНЭЭС 48.8% НЬ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТАХ ЭЗЭЛЖ БАЙНА.


ДООРХ ТООН МЭДЭЭЛЭЛД ДҮГНЭЛТ ӨӨРЧЛӨГДСӨН БОЛОН НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛТЭЙ ТАЙЛАН БАГТААГҮЙ БОЛНО



БҮЛЭГ 1: ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАЖ БАЙГААГААС ЗАРДАЛ НЭМЭГДЭЖ, ТӨСӨВТ АЧААЛАЛ ҮҮСГЭЖ БАЙНА.

Аудитад хамрагдсан 313 төсөл, арга хэмжээний 88 хувь буюу 277 нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, үүнээс газар олголт хийгдээгүй 46, техникийн нөхцөл олгогдоогүй 83, зураг төсөлгүй 135, зураг төсөл нь магадлалаар баталгаажаагүй 224 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгажээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11² дэх заалт, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2³ дахь заалттай нийцэхгүй байна.

Дүрслэл 4. Төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааны зураглал



Зураглалаар улаан шугамын дагуу төлөвлөгдсөн буюу зураг төсөл боловсруулаагүй, зураг төсөл, төсвийн дүнд үндэслэхгүйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байна.

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

³ Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх

1.1. Газар олголтын асуудал бүрэн шийдэгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах нь хэрэгжилт удаашрах, газар чөлөөлөлтөөс үүдсэн өртөг нэмэгдэх эрсдэл үүсгэж байна

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхэд газрын байршил тодорхойгүй байх, хэрэгжих явцад байршлыг өөрчлөн зураг төслийг өөрчлөх, гадна шугам сүлжээний техникийн нөхцөл өөрчлөгдөх зэргээс шалтгаалж төсөвт өртөг өссөн байна. Тухайлбал:

1.1.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөх үед хэрэгжих газрын байршил тодорхойгүй байсан:

- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо, Өргөө цэцэрлэг/;
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/;
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 27 дугаар хороо, 45 дугаар цэцэрлэг/;

1.1.2. Ажил гүйцэтгэгийг шалгаруулсны дараа газрын байршлыг өөрчилсөн:

- Гэр хорооллын гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, СХД 7,9,24,25,40,41,42 хороо/;
- Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар сургууль/;
- Бага сургуулийн барилга, 360 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум, Тыва бага сургууль/;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/;
- Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 149 дүгээр цэцэрлэг, 1 дүгээр корпус/;
- Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг;
- Дүүргийн соёлын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/;
- Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/;
- Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/;
- Ахмадын сувиллын барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 1 дүгээр хороо/;
- Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/;

1.1.3. Төлөвлөсөн газарт багтахгүй үндэслэлээр зураг төслийг бүрэн өөрчилсөн:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо/;

1.1.4. Гэрээ байгуулсны дараа газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо/;
- Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон/;
- Соёлын төвийн барилга, 250 суудал, Говь-Алтай, Халиун сум зэрэг байна.

Барилга байгууламж барих газрын асуудлыг бүрэн шийдвэрлэлгүйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж байгаа нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11⁴ дэх заалттай нийцэхгүй байна.

1.2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа магадлалаар баталгаажсан зураг төсөлд үндэслэхгүй байгаа нь тендерт шалгарсан компанид давуу байдал бий болгож байна

Дүрслэл 5. Төсөвт өртөг нэмэгдсэн шалтгааныг багцалсан байдал



Эх үүсвэр: ТАХ-ний нэгдсэн судалгаанаас


Худалдан авах ажиллагааг зураг төсөлгүй зохион байгуулах, үндэслэсэн зураг төсөл нь магадлалаар баталгаажаагүй байх, тендер зарлахдаа өөр байршил дахь зургийг ашиглах зэрэг асуудал түгээмэл байна. Тухайлбал:

⁴ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

- 1.2.1. Магадлалаар баталгаажаагүй зургийг тендерийн баримт бичигт өгч, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан:
- Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/;
 - "Залуус-1" орон сууцны хорооллын төслийн хонгилын системийн батлагдсан зураг төслөөс эхний ээлжид гүйцэтгэх ажил /Улаанбаатар, ХУД/;
- 1.2.2. Тендер шалгаруулалтын явцад барилга байгууламжийн хүчин чадлыг өөрчилсөн:
- Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар сургууль/;
- 1.2.3. Ажил гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарласан боловч шалгарсан гүйцэтгэгч зураг төслөө боловсруулсан:
- Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, 28 дугаар сургууль/;
 - Ногоон байгууламж, тоглоомын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/;
 - Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/;
 - Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 13, 15, 16 дугаар хороо/;
 - Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг/;
 - Дүүргийн ногоон байгууламж, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/;
 - Насан туршийн боловсролын төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21, 27 дугаар хороо/;
- 1.2.4. Тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулсан:
- Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Биндэр сум/;
- 1.2.5. Тендерийг өөр байршилд баригдсан барилгын зураг төсөл ашиглан зохион байгуулсан:
- Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/;
 - Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, 49 дүгээр цэцэрлэг/;
 - Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/;
 - Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/;
 - Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Дэлгэрцогт сум, 2 дугаар цэцэрлэг/;
- 1.2.6. Нэг маягийн зураг төсөл ашиглаж гүйцэтгэгчийг шалгаруулсны дараа холболтын болон гадна инженерийн шугам сүлжээний ажлын төсвийн дүнгээр төсөвт өртөг нэмэгдэж байна. Тухайлбал:
- Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Булган сум, 4 дүгээр баг/;
 - Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/;
 - Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/;
 - Дотуур байрны барилга, 160 ор /Хөвсгөл, Төмөрбулаг сум/;
 - Сургуулийн барилга, 160 суудал /Ховд, Мөнххайрхан сум/;
 - Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/;
- 1.2.7. Зарим төсөл, арга хэмжээний зураг төслийг шинэчлэлгүйгээр худалдан авах ажиллагаа зарласнаас шалтгаалж төсөвт өртөг нэмэгдсэн байна. Тухайлбал:
- Ахмадын сувиллын барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 1 дүгээр хороо/-2022 онд гэрээ байгуулахдаа 2014 оны нэг маягийн зураг төсөлд үндэслэсэн;

- Гэр хорооллыг дахин төлөвлөх хүрээнд хийгдэх амины орон сууцны гадна инженерийн хангамжийн шугамын ажил /Говь-Алтай, Есөнбулаг сум, Индэрт баг/ 2022 онд гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 2019 онд боловсруулсан зураг төсөл ашигласан;
 - Гэр хорооллыг дахин төлөвлөх хүрээнд хийгдэх амины орон сууцны гадна инженерийн хангамжийн шугамын ажил /Говь-Алтай, Есөнбулаг сум, Харзат баг/ 2022 онд гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 2020 онд боловсруулсан зураг төсөл ашигласан;
 - Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/ 2022 онд гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 2018 онд боловсруулсан зураг төсөл ашигласан,
- 1.2.8. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртгийн дүнд багтаах зорилгоор барилга байгууламжийн ажлыг хэсэгчлэн, ажлын тоо хэмжээг хувааж тендер зарласан, гэрээ байгуулсан зэргээс шалтгаалж төсөвт өртөг нэмэгдэж байна. Тухайлбал:
- Бага сургууль, цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 6 дугаар хороо/;
 - Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Баяннуур сум, 1, 3, 5 дугаар баг/;
 - Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Яруу сум/;
 - Бага сургуулийн барилга, 360 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум, Тыва бага сургууль/;
 - Сургуулийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 9 дүгээр хороо, 76 дугаар сургууль/;
 - Дотуур байрны барилга, 100 ор /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/;
 - Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 43 дугаар хороо/;
 - Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон/;
 - Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжлийн сургалтын төвийн барилга /Улаанбаатар/;
 - Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/;
 - Халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилгын ажил /Дундговь, Цагаандэлгэр сум/;
 - Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний их засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/;
 - Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/;
 - Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум, Говийн ирээдүй цогцолбор/;
 - Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/;
 - Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Бор-Өндөр сум/;
 - Бага сургууль, цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 6 дугаар хороо/ зэрэг байна.

Дүрслэл 6. Төсөвт өртөгт нэмэгдэл үүссэн явцын зураглал



Тендерт шалгарсан гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгч компани зураг төслийг боловсруулж, гүйцэтгэгч нь зураг, төсөв зохиогчийн хувьд захиалагч болж байгаа нь Барилгын тухай хуулийн 38.1.6⁵, 38.1.8⁶, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралт “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4.1-д заасан эрх, чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд баримтлах зарчим алдагдсан, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.1.1⁷, 2.1.1.7⁸ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байх тул Сангийн яаманд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй, холбогдох хууль, журам зөрчсөн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

1.3. Санхүүжилтийг хэрэгжих боломжтой байдлаар төлөвлөөгүйгээс зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч байна

1.3.1. Зарим төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг хэт бага буюу тухайн жилийн төсвийн тухай хуульд төсөвт өртгийн 5-10 хувийг төлөвлөснөөс шалтгаалж барилга угсралтын ажил эхлээгүй байна. Тухайлбал:

- Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 13, 15, 16 дугаар хороо/;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Эрдэнэдалай сум, 2 дугаар цэцэрлэг /;
- "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ зэрэг байна.

⁵ барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрч, баталгаажуулах;

⁶ барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах;

⁷ төслийн саналыг энэ журамд зааснаар хүлээн авах, нэгтгэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналтыг хэрэгжүүлэх,

⁸ хууль, журмын шаардлага хангаагүй төслийн санхүүжилтийг олгохгүй байх;

1.3.2. Захиалагч олон удаа солигдож, залгамж халаа алдагдсан, магадлал хийх, гэрээ байгуулах, асуудал шийдвэрлэх үйл явц удаашралтай зэрэг шалтгаанаас төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилж, төсөвт өртөг нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/ - санхүүжих дүнг 2011-2022 онуудад төсөвт өртгийн 5-20 хувиар төлөвлөсөн, зарим жил санхүүжилт төлөвлөөгүй, захиалагчаар 2011-2012 онд ЭМЯ, 2012-2013 онд ССАЖЯ, 2013-2016 онд ЭМСЯ, 2016-2019 онд БСШУСЯ тус тус ажилласан ба одоо БТСУХ байна;
- Сургуулийн өргөтгөлийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар сургууль/ - газрын байршил өөрчилснөөс 2019 оны 7 дугаар сард газар шороо, суурь, ус зайлуулах системийн ажил хийгдсэн боловч төсвийг 2020 оны 12 дугаар сард магадлалаар баталгаажуулсан, нэмэлт санхүүжилтийн гэрээг 2022 оны 5 дугаар сард буюу нэмэлт ажил хийснээс хойш 34 сарын дараа, төсөв нь магадлалаар баталгаажсанаас хойш 17 сарын дараа өөрчлөхдөө үндсэн барилгын 2018 онд магадлалаар баталгаажсан дүнгээр байгуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁹ дахь заалт /2022.11.11-ний өдрийн өөрчлөн найруулахаас өмнөх заалт/- хэрэгжээгүй байна.

Барилга байгууламжийн ажил үргэлжлэх хугацаа богино, өвлийн нөхцөлд үргэлжлүүлэхэд нэмэлт зардал шаардагддаг зэрэг үйл ажиллагааны онцлог байдлыг харгалзан хэрэгжих хугацаа, санхүүжилтийг төлөвлөдөг байх шаардлагатай байна.

1.4. Төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ холбогдох тооцоо судалгаа хийгээгүйгээс хэрэгжилт удааширч, үр өгөөжгүй болох эрсдэл үүсэж байна

Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө магадлалаар баталгаажуулсан зураг төсөлд үндэслээгүй, зураг төслийг боловсруулахдаа хэрэгжих байршлын хүн амын тоо, байгаль, цаг уурын онцлог зэрэг бодит нөхцөл байдалд үндэслээгүйгээс шалтгаалж нэмэлт зардал үүссэн байна. Тухайлбал:

1.4.1. Зураг төсөлгүйгээр барилга угсралтын ажил гүйцэтгэж, санхүүжилт олгосон:

- Сумын төвийн шинэчлэл /Дорнод, Баян-Уул сум/;
- Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/;
- Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/;

1.4.2. Хэрэглэгчгүйн улмаас ашиглагдаагүй байх хугацаанд авто замын ажлаас шалтгаалж шугамд гэмтэл гарч нэмэлт өртөг үүссэн:

- 1-р хороолол Орбит чиглэлийн цэвэр усны шугамын 1 ба 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан/;

1.4.3. Зарим барилга байгууламжийн зураг төслийг иж бүрэн боловсруулаагүйгээс шалтгаалан нэмэлт ажлын дүнгээр төсөвт өртөг өссөн байна. Тухайлбал:

- Үерийн далан /Өвөрхангай Хархорин сум/;
- Эрдэнэзуу музейн “Аялал жуулчлалын гудамж” төсөл /Өвөрхангай, Хархорин сум/;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/;

⁹ 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

- Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 3 дугаар баг, "Дуурсах" 2 дугаар цэцэрлэг/;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо/;
- Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр, /Улаанбаатар/;
- Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/;
- Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/;
- Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/;
- Цэцэрлэгийн барилга. 150 ор /Дорнод. Хэрлэн сум, 11 дүгээр баг/;
- Үндэсний номын сангийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/;
- Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/;
- Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/;
- Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/;
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/;
- Сургуулийн хичээлийн байрны барилга, 160 суудал /Говь-Алтай, Дэлгэр сум, Гуулин тосгон/;
- Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Цээл сум/ зэрэг байна.

Төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулсны дараа газрын байршил өөрчлөх, инженер геологийн дүгнэлтээс шалтгаалж суурийн хийцлэл, зураг төсөл өөрчлөгдөх асуудал гарч байгаа нь Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. Зураг төсөлд тавих шаардлага. 12.1.1¹⁰, 24 дүгээр зүйлийн 24.1.2¹¹ дахь заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

¹⁰ эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх;

¹¹ барилга байгууламжийн байршил, байгаль, цаг уурын нөхцөл, газар чөлөөлөх асуудлыг тусгасан байх,

БҮЛЭГ 2: БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙГ ТООЦОХ, ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА ҮҮССЭН БАЙНА

2.1. Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан, төсөвт өртгийг нэмэгдүүлж нэмэлт гэрээ байгуулсан байна

Дүрслэл 7. Олон жил үргэлжилж буй төсөл арга хэмжээ

ОЛОН ЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

2005 он	БХБС <ul style="list-style-type: none">1-р хороолол Орбит чиглэлийн цэвэр усны шугамын 1 ба 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан/
2010 он	ХХААХҮС <ul style="list-style-type: none">Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/
2011 он	СоС, МУС, ОНБТСҮХД, БХБС <ul style="list-style-type: none">Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сумБарилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/
2012 он	МУС, ОНБТСҮХД, СоС, БШУС <ul style="list-style-type: none">Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо/Усан бассейн спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/
2013 он	БХБС, БШУС <ul style="list-style-type: none">Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д 0800-ийн гол шугамыг 01000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/
2014 он	БХБС, МУС, ОНБТСҮХД, СоС <ul style="list-style-type: none">Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/Үндэсний номын сангийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/Сумын төвийн шинэчлэл /Дорнод, Баян-Уул сум/
2015 он	БШУС <ul style="list-style-type: none">Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/

Аудитад хамрагдсан нийт төсөл, арга хэмжээний анхны төлөвлөсөн төсөвт өртөг нь дунджаар 19.7 хувиар, гэрээний үнийн дүн 18.4 хувиар өсөж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

2.1.1. Зарим төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 3-6 удаа сунгасан, 5-аас дээш жил үргэлжилсэн боловч 90-ээс доош хувийн гүйцэтгэлтэй байна. Тухайлбал:

- Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/;

- Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/;
- Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/;
- Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга /Улаанбаатар, Хан-уул дүүрэг, 8 дугаар хороо/;
- Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/;
- Халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилгын ажил /Дундговь, Цагаандэлгэр сум/;
- Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/;

2.1.2.Зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ барилгын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй байна. Тухайлбал:

- Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Биндэр сум/ - спорт заалны шилэн блок цонхыг зургийн дагуу угсраагүй, дам нурууны бетон, хийцлэлийн бат бэхийг захиалагчийн хяналт гүйцэтгэгч нар шалгаж, шаардлагатай бол хөндлөнгийн шинжээч ажиллуулах;
- Бага сургууль, цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 6 дугаар хороо/ - төмөр бетон каркасны ажил гүйцэтгэж байх явцад хэв хашмал ханарсан, гадна фасадын дулаалгын хөөсөнцөр хаших хийцээс хөндийрсөн;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/ - барилгын Х1 тэнхлэг Y1-Y2, Х7 тэнхлэг Y1-Y2 тэнхлэг хоорондох 69,7 м2 талбайг эзэмшил газарт багтаагүй гэсэн үндэслэлээр хасаж гүйцэтгэсэн;
- Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр, Улаанбаатар - зоорийн давхрын гадна ханын чийг тусгаарлах хийцлэл шаардлага хангахгүй, чийг, цан цохисон;
- Соёлын төвийн барилга, 240 суудал /Өвөрхангай, Баянгол сум/ - арматурын диаметрийг зургаас багасгаж хийсэн, суурийн дам нурууг тэгш түвшинд цутгаагүй, гадна хаалга дулаан алдагдал ихтэй учир хөөсөнцрөөр битүүмжилсэн, дотор ханын дүүргэлтийн өрлөгийг технологийн горим алдаж өрснөөс суулт өгч, дам нуруу болон өрлөгийн хооронд цууралт, дам нурууны хооронд хагарал үүссэн, шалны доорх шороог нягтруулаагүйгээс шал суулт өгч хана болон шалын хооронд зааг үүссэн, дотор хаалга эвдэрсэн, дээврийн ус зайлуулах систем чанаргүй материалаар хийж, хананд бэхлээгүйгээс салж унасан;
- Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Манлай сум/ - гадна фасадыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, газар хөдлөлийн заадасны дүүргэлт, чигжээсийг хийгээгүй, газар хөдлөлийн заадсыг хөөсөнцөр гадна фасадад гаргаагүй учир босоо хагарал гарсан, гадна өнгөлгөөний тоосгоны өрлөгийн заадас жигд биш, модон ялуун дээр хийсэн нь өрөгт бүтээцийн шаардлага хангахгүй болсон, дотор өрлөгийн ялууны оронд арматур төмөр ашигласан;
- Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор, /Өвөрхангай, Төгрөг сум, 1 дүгээр баг/ - дотор халаалт, цэвэр усны шугамын цутгамал суваг, худаг, цутгамал төмөр бетон шат болон суурийн дам нурууны түвшнийг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, 1-р давхрын цутгамал төмөр бетон хучилтын өрлөгийн хэсгийн хучилтыг хийгээгүй;

- Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өвөрхангай, Сант сум/ - гадна дулаан, цэвэр усны шугамын лотки, худгийг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, цутгамал төмөр бетон суурийн дам нуруунд босоо цуурал 4 хэсэгт гарсан;
- Музейн барилга /Өвөрхангай, Арвайхээр/ - гадна конкревалл хананд босоо болон хөндлөн цууралт үүссэн шалтгааныг гүйцэтгэгч, материал нийлүүлэгч болон зургийн зохиогчид бүрэн олж тогтоогоогүй, арилгаагүй;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум/ - 3 баганын хэмжээ алдсанаас үүдэн баганын гаргалгаа арматурууд буруу гарсан, баганын босоо арматуруудыг хэмжээнд нь оруулахын тулд матаж далийлгасан, шалыг зургийн дагуу дулаалаагүй;
- Сургуулийн барилгын өргөтгөл 320 суудал /Говь-Алтай Дэлгэр/ - каркас болон дүүргэгч ханын хооронд ан цав, заадлын хагарал гарсан, шатны хонгилын дээр төлөвлөгдсөн дээврийн шилэн хийцлэлийг зориулалтын бус шилээр зургаас зөрүүтэй гүйцэтгэснээс дотор засал гандсан, дээврээс ус орсон, урлаг заалны таазны түвшин алдагдсан, агааржуулалтын систем хийсэн эсэх тодорхойгүй;
- Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум/ - сувгийн хучилтын хавтанг үйлдвэрээс худалдан авч, тээвэрлэж, угсрахаар зураг төсөлд тусгасан боловч ажлын талбайд цутгасан;
- Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/ - халаалтын радиаторыг цонхны хүрэн дотор угсарсан нь барилга угсралтын технологи зөрчсөн, спорт заалны 1 давхрын гадна фасадын өнгөлгөөний тоосгон хана өрөх бетонон чих хучилтад цутгаагүй, А блокийн дээврийн ус зайлуулах налууг буруу хийснээс дээвэрт ус тогтож, хавтгай дээврийн хийц нь усанд норж нэвчилт өгсөн зэрэг байна. /Эх үүсвэр: шинжээчийн дүгнэлтээс/

Захиалагчид нь барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтийг тухай бүр дүгнээгүй, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, гэрээт хугацаанд нь ашиглалтад оруулах талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь үр дүнгүй байна.

Сангийн яам нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6¹², Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.1.1¹³, 2.1.2.12¹⁴ -д тус тус заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2.2. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийж байгаа хүний нөөц хязгаарлагдмал байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна

2.2.1. Барилга, байгууламжийн “зураг төслийн магадлал”-ыг холбогдох хуульд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16:

"барилга байгууламжийн зураг төслийн магадлал" гэж барилга байгууламжийн зураг төсөл, технологи, өргөх байгууламжийн сонголт, хот болон архитектур төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бэхийн шийдэл барилга байгууламжийн норм,

¹² Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих,

¹³ Төслийн саналыг энэ журамд зааснаар хүлээн авах, нэгтгэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналтыг хэрэгжүүлэх,

¹⁴ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн хэрэгжилттэй танилцах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах

нормативын баримт бичгийн шаардлага, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагааг”,

- ЭХТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.32:

“магадлал” гэж эрчим хүчний барилга байгууламж, түүнд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, техник, технологи, нэгдсэн төсөв нь норм, дүрэм, стандартын шаардлага хангасан талаар мэргэжлсэн шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагааг”

- Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20:

“зураг төслийн магадлал” гэж авто зам, замын байгууламжийн зураг төслийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь байгаль, цаг уур, газар орны нөхцөлд зохицож байгаа эсэх, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдал нь авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг; гэж тус тус тодорхойлжээ.

2.2.2. Барилга, байгууламжийн зураг төслийн магадлалыг зохион байгуулах, магадлалын дүгнэлтийг гаргах мэргэжлийн эксперт болон хуулийн этгээдийг шалгаруулах эрхийг МУЗГ-ын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 51 дүгээр “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” тогтоолоор БХТ-д, 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар ЗТХТ-д, 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” тогтоолоор ЭХҮТ-д тус тус шилжүүлсэн байна.

Мөн дээрх байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг дараах байдлаар баталжээ.

Хүснэгт №1. БХТ, ЗТХТ, ЭХҮТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

<p><i>Зам, тээврийн хөгжлийн төв</i></p>	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Улсын Их Хурал, Засгийн газар, Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зам, тээврийн талаар гаргасан бодлого шийдвэр, Авто замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийн хүрээнд Монгол улсын авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, 2. Арчлалт, засварын ажлыг удирдан зохион байгуулах, 3. зам тээврийн чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх, 4. Стандарт норм нормативын, баримт бичиг боловсруулах, 5. Авто зам, замын байгууламжийн зураг төслийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах, 6. Авто замын салбарын мэргэжилтэй ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлын зохион байгуулах, 7. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын техник технологийн хяналтыг хэрэгжүүлнэ.
<p><i>Эрчим хүчний үндэсний төв</i></p>	<ol style="list-style-type: none"> 1. Эрчим хүчний салбарт улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих 2. Эрчим хүчний барилга байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний ажлын зураг төсөвт магадлал, шүүмж, дүгнэлт хийх, эдгээртэй холбоотой ажлыг зохион байгуулах 3. Салбарын хэмжээнд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, ажлыг зохион байгуулах, мэргэшлийн зэргийг аттестатчилах арга хэмжээг зохион байгуулах 4. Цахилгаан болон дулаанжуулалтын тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор түлш, уур-ус, тос, металл судлал, гагнуурын хяналт шинжилгээ хийх, техникийн дүгнэлт гэргэх 5. Эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтад сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах 6. Эрхэлсэн асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох 7. Компанийн үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх


	8. Компани техник хяналт тавигдсан эрчим хүчний барилга байгууламжийн хяналт, зураг төсөв, холбогдох материалаар мэдээллийн сан бүрдүүлэх, сонирхогч байгууллага, иргэдэд энэ талын мэдээллээр хангах
Барилгын хөгжлийн төв	<ol style="list-style-type: none"> 1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах; 2. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах; 3. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; 4. Барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; 5. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах; 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох; 7. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох; 8. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх; 9. Архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах; 10. Барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах; 11. Улсын төсөв болон гадаад, дотоодын санхүүжилтээр хот байгуулалт, барилгын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 12. Барилгын салбарын ажилтныг давтан сэргэх, мэргэжил дээшлүүлэх мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтын ажлыг зохион байгуулах 13. Барилга байгууламжийн норм, нормативийн баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах 14. Барилга байгууламжийн норм нормативийн санг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах 15. Барилга, нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах 16. Хот байгуулалт, барилга нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах.

Эх үүсвэр: Төвүүдийн дүрмээс

Хөгжлийн төвүүд нь барилга байгууламжийн норм нормативын баримт бичиг боловсруулах, зураг төслийг боловсруулах, магадлах үйл ажиллагааг зохион байгуулах, төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг шалгаруулах, хэрэгжүүлэхэд хяналт тавих, санхүүжилт олгох, ашиглалтад хүлээн авах зэрэг барилга байгууламж хэрэгжиж дуусах хүртэл бүх үйл ажиллагаанд оролцох чиг үүрэгтэй байна. Төвүүдийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын үр дүнг тооцох шаардлага үүссэн байна.

2.2.3. Дээрх байгууллагууд нь 2019-2023 онуудад нийт 16,631.0 ширхэг магадлалын дүгнэлтийг баталгаажуулсан байна.

Дүрслэл 8. БХТ, ЗТХТ, ЭХҮТ-ийн 2019-2023 оны хооронд баталгаажуулсан МЕД



2.2.4. БХБС-ын 2019 оны 213 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ын хүрээнд дараах байдлаар ажилласан байна. Үүнд:

- **Барилгын хөгжлийн төв:**

Барилга, байгууламжийн зураг төслийн магадлалыг зохион байгуулах, магадлалын дүгнэлтийг гаргах мэргэжлийн эксперт болон хуулийн этгээдийг шалгаруулах эрхийг МУЗГ-ын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 51¹⁵ дүгээр тогтоолоор БХТ-д шилжүүлсний дагуу БХБС-д 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 213¹⁶ дугаар тушаалаар "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам"-ыг шинэчлэн баталж, 2020, 2022 онуудад нийт 268 экспертийг сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаатай магадлал хийх эрх олгосон байна. Харин дээрх хугацаанд хуулийн этгээд шалгараагүй байна. Үүнд:

Хүснэгт №2. БХТ-өөс 2020, 2022 онд сонгон шалгаруулж, эрх олгосон эксперт

БХТ-ийн Захирлын 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/27В дугаартай тушаал	БХТ-ийн Захирлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны А/650 дугаартай тушаал
<ul style="list-style-type: none"> - Хот төлөвлөлт, барилга архитектурын зураг төслийн эксперт – 60; - Барилга бүтээцийн зураг төслийн эксперт – 49; - Барилга байгууламжийн дулаан хангамж, агаар сэлгэлтийн зураг төслийн эксперт – 20; - Барилга байгууламжийн холбоо дохиолол, мэдээллийн системийн зураг төслийн эксперт – 9; - Цахилгаан шугам сүлжээ, цахилгаан хэмжил зүй реле хамгаалалт, автоматжуулалт, сэргээгдэх эрчим хүч, дэд станцын барилга байгууламжийн зураг төслийн эксперт – 25; - Цэвэрлэх байгууламж, ус хангамж ариутгах татуургын байгууламжийн зураг төслийн эксперт – 14; - Усны нөөц, усны барилга байгууламжийн зураг төслийн эксперт – 9; - Барилгын төсөв үнэ бүрдэл, барилгын 1, хот төлөвлөлтийн ТЭЗҮ, судалгаа шинжилгээ, төлөвлөлтийн хүрээнд эксперт – 43; - Нефьт, нефьтийн бүтээгдэхүүн, хийн хангамжийн чиглэлээр барилга байгууламжийн зураг төслийн эксперт – 5; - Инженер геологи, хайгуул судалгааны чиглэлээр – 9; - Өндөржилт, геодезийн чиглэлээр – 4; - Олон нийт үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төслийн эксперт – 2. 	<ul style="list-style-type: none"> - Хот төлөвлөлт, барилга архитектурын зураг төсөлд – 3; - Барилга бүтээцийн зураг төсөлд – 4; - Барилга байгууламжийн дулаан хангамж, агаар сэлгэлтийн зураг төсөлд – 1; - Цахилгаан шугам сүлжээ, цахилгаан хэмжил зүй, реле хамгаалалт, автоматжуулалт, сэргээгдэх эрчим хүч, дэд станцын барилга байгууламжийн зураг төсөлд – 3; - Цэвэрлэх байгууламж, ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн зураг төсөлд – 1; - Усны нөөц, усны барилга байгууламжийн зураг төсөлд – 3; - Барилгын төсөв үнэ бүрдэл, барилга, хот төлөвлөлтийн ТЭЗҮ, судалгаа шинжилгээ, төлөвлөлтийн хүрээнд – 2; - Олон нийтийн үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төсөлд – 1; - Өндөржилт, геодезийн чиглэлээр – 1;
Нийт 249	Нийт 19

¹⁵ “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай”

¹⁶ “Журам батлах тухай”

Мөн дээрх БХБС-ын 2019 оны 213¹⁷ дугаар тушаалаар баталсан журмын 2.1¹⁸ дэх заалтад заасны дагуу иргэний хувьд 2.2.2-т “*зураг төслийн байгууллагад тухайн мэргэжлийн чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан байх*” гэж заасан нь зураг төслөөс бусад чиглэлээр ажиллаж буй инженерүүдийн, хуулийн этгээдийн хувьд 2.3.3-т “*барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх чиглэл тус бүрээр 2-оос доошгүй орон тооны эксперттэй байх бөгөөд хөдөлмөрийн гэрээ байгуулсан байх*” гэж заасан нь тухайлсан чиглэлд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өрсөлдөх чадварыг хязгаарласан байна.

- **Зам тээврийн хөгжлийн төв:**

Барилга, байгууламжийн зураг төслийн магадлалыг зохион байгуулах, магадлалын дүгнэлтийг гаргах мэргэжлийн эксперт болон хуулийн этгээдийг шалгаруулах эрхийг МУЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар ЗТХТ-д шилжүүлсний дагуу ЗТХТ-ийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар “Зам замын байгууламжийн зураг төслийн баримт бичигт магадлал хийх экспертийг сонгон шалгаруулах журам”-ыг баталж, 2022, 2023 онуудад нийт 90 экспертийг сонгон шалгаруулж, 1 жилийн хугацаатай магадлал хийх эрх олгосон байна. Мөн дээрх хугацаанд хуулийн этгээд шалгараагүй байна. Үүнд:

Хүснэгт №3. ЗТХТ-өөс 2022, 2023 онд сонгон шалгаруулж, төсөвт магадлал хийх эрх олгосон эксперт

ЗТХТ-ийн Захирлын тушаал 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/09	ЗТХТ-ийн Захирлын тушаал 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/27
<ul style="list-style-type: none"> - Авто замын, гүүрийн төсөвт 3 эксперт - Цахилгаан, гэрэлтүүлгийн төсөвт 4 эксперт - Дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын төсөвт 2 эксперт - Төмөр зам, дохиолол болон радио холбооны төсөвт 2 эксперт 	<ul style="list-style-type: none"> - Авто замын, гүүрийн төсөвт 3 эксперт - Цахилгаан, гэрэлтүүлгийн төсөвт 4 эксперт - Холбооны зураг төсөл төсөвт 1 эксперт - Дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын төсөвт 2 эксперт - Төмөр зам, дохиолол болон радио холбооны төсөвт 2 эксперт
Нийт 11	Нийт 12

Хүснэгтээс харахад улсын хэмжээнд авто замын барилга, байгууламжийн төсөвт магадлал хийх эрх авсан эксперт 3 байгаа нь хүний нөөц хангалтгүй байгааг харуулж байна.

- **Эрчим хүчний үндэсний төв:**

Эрчим хүчний сайдын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 188 дугаар тушаалаар эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журмыг баталсан байна.

Монгол улсын засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоолоор “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлэн “ Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулахаар тогтоосон байна.

Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалаар зураг төсөлд магадлал хийх орон тооны бус экспертүүдийн нэрсийг батлан 1 жилийн хугацаатай гэрээ байгуулах эрх олгосон байна. Нийт зураг төсөл, төсвийн 71 эксперт шалгарсан байна

¹⁷ “Журам батлах тухай”

¹⁸ 2.1.Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3, 25.5, 25.8 дахь заалтад заасан барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдэд магадлал хийх эрх олгох сонгон шалгаруулалтад энэ журмын 2.2 болон 2.3-т заасан шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд оролцоно.

Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг шалгаруулахдаа мэргэжил, ажилласан байдлаар хязгаарласан байдалд хяналт, шинжилгээ хийж, экспертийн тоо цөөн, ачаалал их байх, магадлалын дүгнэлт чанаргүй болох эрсдэлийг арилгах шаардлагатай.

2.2.5. Салбарын хуулиудад дараах ажлуудад магадлал хийхээр тусгасан байна.

Хүснэгт 4

Барилгын тухай хууль	Авто замын тухай хууль	Эрчим хүчний тухай хууль
<ol style="list-style-type: none"> Газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөв;; Газар хөдлөлтийн долоогоос доош баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөв; Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд Инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв. Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ 	<ol style="list-style-type: none"> Авто зам, замын байгууламжийн инженерийн шугам сүлжээний нарийвчилсан зураг төсөл, барилгын ажлын төсөвт өртгийн тооцоо, инженер-геологийн судалгааны тайлан; Хийц, технологийн онцлог, төвөгшилтэй шийдэл бүхий авто зам, замын байгууламж (хурдны зам, гүүрэн гарам, олон түвшний уулзвар, хонгил зам, цахилгаан хангамж, дохиолол холбоо гэх мэт)-ийн бүрдэл хэсгийн нарийвчилсан зураг төсөлд хэсэгчлэн болон үе шаттайгаар 	<ol style="list-style-type: none"> Эрчим хүчний барилга байгууламж, түүнд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, Техникийн болон ажлын зураг, техник, технологи, нэгдсэн төсөв Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэл

Эх үүсвэр: БТХ

БТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.5¹⁹-д заасны дагуу барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт орсон тохиолдолд зураг төсөлд дахин магадлал хийхээр заажээ.

Аудитад хамрагдсан нийт 313 төсөл арга хэмжээний магадлалын дүгнэлтүүд дараах нэршлээр гарсан байна. Үүнд:

- үлдэгдэл ажлын - 19,
- өөрчлөлтийн ажлын – 39,
- холболтын ажлын – 33,
- нэмэлт ажлын – 103 магадлалын дүгнэлт баталгаажуулсан байна.

Үүнээс 103 төсөл, арга хэмжээний нэмэлт ажлын магадлалууд нь дараах утгатай байна. Үүнд:

¹⁹ 25.5.Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

- Анхны магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвт орхигдсон болон дутуу тооцогдсон ажлаар;
- Захиалагчийн хүсэлтээр гүйцэтгэсэн нэмэлт ажлын тоо хэмжээгээр;
- Газрын байршил өөрчлөгдсөнөөс үүссэн ажлын тоо хэмжээгээр;
- Худалдан авах ажиллагаанд тусгаагдаагүй нэмэлт ажлын тоо хэмжээгээр;
- Анхны ажил гүйцэтгэх гэрээнд тусгаагдаагүй ажил зэрэг байна.

Магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маяггүй, нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгахгүй байгаа зэрэг нь захиалагч, гүйцэтгэгч нарт ойлголтын зөрүү үүсэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд илүү, дутуу дүнгээр тусгах эрсдэлийг бий болгож байна.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нар барилга байгууламжийн төсөвт өртгийн нэмэлт зардлын тооцоонд дотоод аудит хэрэгжүүлээгүй байна

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийг заасан байх бөгөөд түүн дотроо 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж тус тус заасан байна.

2.3.1. Аудитын хүрээнд нийт 17 төсвийн ерөнхийлөн захирагчид “Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зураг төсөл, төсөвт өртгийн нэмэгдэл зардалд хийсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын тайланг ирүүлэх тухай” албан бичгийг 2023 оны 11 дүгээр сард хүргүүлэхэд 10 ТЕЗ хариу ирүүлж, бусад нь ирүүлээгүй байна.

Албан бичгийн хариуг ирүүлсэн:

1. Байгаль, орчин аялал жуулчлалын яам;
2. Эрүүл мэндийн яам;
3. Хууль зүй, дотоод хэргийн яам;
4. Соёлын яам;
5. Зам, тээврийн хөгжлийн яам;
6. Барилга, хот байгуулалтын яам;
7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
8. Биеийн тамир, спортын улсын хороо;
9. Онцгой байдлын ерөнхий газар байна.

Эдгээрээс Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Онцгой байдлын ерөнхий газар нь дотоод аудит хийсэн тухай тайлан мэдээг ирүүлсэн ба бусад 6 нь дотоод аудит хийгээгүй, ирэх жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах тухай хариу ирүүлсэн байна.

2.3.2. Барилга, хот байгуулалтын яам нь Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.10²⁰, 47.2.13²¹-д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газраас ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын

²⁰ зураг төсөл боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд;

²¹ барилга байгууламжийн төсөвт өртөг, үнэ бүрдэлд

27-ны өдрийн 9/4292 дугаартай албан бичигт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2022 онд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах, магадлал хийх үйл ажиллагаа, барилга байгууламжийн төсөвт өртөг, үнэ бүрдэл, төсөвт өртгийн нэмэгдэлд хариуцсан улсын байцаагч ажиллаагүйн улмаас хяналт шалгалт хийгдээгүй” талаар дурдсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид нь барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дотоод аудитыг хийж гүйцэтгээгүй байна. Мөн Барилгын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, барилга байгууламжийн техникийн улсын хяналт хийгдэхгүй байна. Иймд Барилга, хот байгуулалтын яаманд барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа, барилга байгууламжийн төсөв, үнэ бүрдэлд техникийн хяналт хэрэгжүүлж тайланг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2.4. **Барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн тооцоог гүйцэтгэж байгаа инженер, төсөвчин, экспертүүдийн ур чадварыг сайжруулах, ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай байна**

Зарим барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, магадлалаар баталгаажуулах үйл ажиллагаанд холбогдох норм, дүрэм мөрдөөгүй байна.

2.4.1. Магадлалаар баталгаажсан төсвийн тооцоонд ажлын тоо хэмжээ орхигдуулснаас дахин магадлал хийж, төсөвт өртөг нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/;
- Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Дундговь, Сайнцагаан сум/;
- Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний их засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/;
- Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/;
- Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Биндэр сум/;
- Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/;
- Дотуур байрны барилга, 150 ор /Дорнод, Цагаан-Овоо сум/;
- Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 14 дүгээр сургууль/;
- Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/;
- Соёлын төвийн барилга, 240 суудал /Хөвсгөл, Арбулаг сум/;
- Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дулаалга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, 59 дүгээр байр, 15 дугаар хороо, 32 дугаар байр, 18 дугаар хороо, 43 дугаар байр/ зэрэг байна.

2.4.2. Зарим барилга байгууламжийн нэмэгдэл зардлын төсвийг тооцохдоо холбогдох норм дүрмийг баримтлаагүй байна. Тухайлбал:

- Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Биндэр сум/ - дээврийн хийцлэлд 9.5 сая төгрөгийн үнсийг 430 км-ээс буюу Улаанбаатар хотоос тээвэрлэхээр 65.8 сая төгрөгийн тээврийн зардал илүү тусгасан, бетон зуурмагийг талбайд цутгахаар оруулсан боловч бетоныг задлаагүй, давхардуулан тооцсон, таазны эмульс, ханын шавардлагын ажлыг илүү тусгасан алдааг залруулснаар 262,813,689.00 төгрөгийн хасагдах зардал үүссэн;
- Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ - “Б” блокийн барилгыг дуусгах ажлын төсвийн тооцоонд гүйцэтгэлээр авсан төмөр бетон шал 110.53 м³, чулуун хөвөнгөөр дулаалах 303.1 м² ажлуудын 165.6 сая төгрөгийн ажлыг нэмэлт төсвийн тооцоонд давхардуулан тооцсон;

- Дүүргийн ногоон байгууламж, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг/ - зарим тоног төхөөрөмжийн үнийг барилгын материалын зардалд оруулан тооцсон, хогийн сав, сүүдрэвч, тоглоом, дасгалын төхөөрөмжийн үнийг тооцохдоо зах зээлийн үнийн судалгаа, харьцуулалт хийсэн эсэх нь нотлогдохгүй;
- Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/ - дулааны шугам, бохирын худгийн буулгалтын ажлыг давхардуулан тооцсон, гадна хашааны төсвийг зураг төсөлгүй хийсэн, квадрат төмрийг жишиг хашааны орцоос хэт өндөр тооцсон алдааг засварласнаар магадлалаар баталгаажсан төсөвт өртгөөс 247,311,178.00 төгрөгийн хасагдах зардал үүссэн;
- Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Дундговь, Сайнцагаан сум/ - А блокийн төсөвт төмөр бетон суурь, каркас угсралтын ажилд бэлэн бетон зуурмаг ашиглахаар тооцсон ч зуурмаг талбайд бэлдэх ажлыг давхардуулан тооцсон, шалны ажилд зуурмаг бэлдэх ажлыг илүү тооцсон;
- Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор Өмнөговь, Манлай сум - дулаан механикийн зураггүйгээр төсвийн тооцоо хийж, магадлалаар баталгаажуулсан;
- Соёлын төвийн барилга, 200 суудал /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/ - хөөсөнцөр дулаалгатай төмөр сэндвич хавтангаар дээвэр хийх ажилд усны хамгаалалтын тагийн орцыг үндэслэлгүй өндрөөр тооцсон;
- Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/ Залуус-1 хорооллын дулаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ - бетонон ханын гадаргууд ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх ажилд шаардагдах хар тосны орцыг нэг м²-д 28,28 кг-аар буюу үндэслэлгүй өндрөөр тооцсон;
- Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/ - гадна фасадын хөөсөнцөр хавтан 150 мм-ийн дулаалга, өнгөлгөөний материалыг металл хавтан, чулуун хөвөн, шилэн хийцээр сольсон өөрчлөлтийг давхардуулан тооцсон;
- Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Тонхил сум/ - төсвийн тооцоонд гадна бохирын цооног, тогооны барилгын ажлыг давхардуулан тооцсон;
- Насан туршийн боловсролын төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21, 27 дугаар хороо/ - шалны талбайг бодохдоо зурагт 216.2м² байгааг 690.8 м²-аар тооцсон, аргачилсан заавар /БД81-101-01/-ын дагуу шалны хэмжээ өсгөх коэффициент 1.02-ыг өөрчлөн 1,2 болгож өсгөсөн алдаа гарсан ба төсвийн тооцоонд паркетан шалны хэмжээ 932,58 м² буюу байх ёстой орцоос 708 м²-аар илүү тусгасан зэрэг байна.

Барилга байгууламжийн зураг төсөл, төсвийн тооцоонд илэрсэн эдгээр алдаа зөрчил нь Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1²², Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсөв зохиох дүрэм”-тэй нийцэхгүй байна. Мөн алдаатай боловсруулсан төсвийн тооцоог магадлалаар баталгаажуулсан байгаа нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм”-д нийцэхгүй байх тул Барилга, хот байгуулалтын яаманд магадлал хийх үйл ажиллагаанд гарч байгаа алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

²² Батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх,

2.5. Барилга байгууламжийн төсөвт өртгийг төлөвлөх, гүйцэтгэчийг шалгаруулах тендер зарлах үйл ажиллагаанд төсвийн томсгосон норм үнэлгээг хэрэглэх шаардлага үүссэн байна

Барилга, хот байгуулалтын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 425 норм нормативын баримт бичиг байна. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт, арга зүйн 80,
- Ерөнхий техникийн 50,
- Хот байгуулалт, байгууламжийн 98,
- Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн 41,
- Барилгын бүтээц эдлэхүүний 42,
- Барилгын материал, бүтээгдэхүүний 2,
- Барилга байгууламжийн эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн 112 байна.

Дүрслэл 9. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, норматив



2.5.1. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 203 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм” /БД 81-106-16/, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 114 дүгээр тушаалаар “Барилга байгууламжийн үнийн индекс тооцох дүрэм” /БД 81-105-17/, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 206 дугаар тушаалын хавсралтаар “Барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлал” /БД 81-104-22/-ыг тус тус баталсан боловч хөрөнгө оруулалтыг төлөвлөх, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд мөрдөх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

2.5.2. Гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт барилга байгууламжийн төсвийн анхан шатны баримт бичиг болох

нэг бүрчилсэн төсвийн тооцоо, үе шатны ажлын тоо хэмжээг үндэслэн зохион байгуулж байгаа нь “төсвийн тооцоонд ажлын тоо хэмжээ орхигдуулсан, дутуу тооцсон гэх” асуудлаар төсөвт өртөг нэмэгдэх, нөгөө талдаа залилангийн эрсдэлийг үүсгэж байна. Жишээлбэл:

Тус жишээнд гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн баримт бичигт орсон газар шорооны ажлын тоо хэмжээ, нэг бүрчилсэн төсвийн тооцоог үндэслэн гүйцэтгэгчийг шалгаруулсны дараа төсөвт тусгагдаагүй ажлын төсвийг тооцож, магадлалаар баталгаажуулсан байна. Үүнээс үүдэн зөвхөн газар шорооны ажлын ажиллах хүчний зардал нь 2.9 сая төгрөгөөр өссөн харагдаж байна.

Хүснэгт 5. Төсөвт ажлын тоо хэмжээ орхигдуулснаас үүдсэн төсөвт өртгийн нэмэлтийг харьцуулсан жишээ /төгрөг/

Тендерт өгсөн төсвийн газар шорооны ажлын тооцоо									
үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг	Тариф т цалин	Нийт цалин	Бүгд цалин
01-210-08	Суурийн нүхийг механизмаар ухаж овоолох	М3	520.78	2.0/2	0.01/	5.364/	5212/5 212	27957/	27,957.00
01-060-03	Суурийн нүх гараар засаж ухах	М3	16.11	2.9/2	4.86/	78.343/	6056/5 212	474445 /	474,445.00
01-400-03	Мөн хөрсийг түрж хүнхээл ба шуудууг булах	М3	316.7	/2	/	/	/5212	/	
01-070-02	Шороогоор эргүүлж гараар булах	М3	55.89	1.3/2	1.84	102.58 6/	4554/5 212	467177 /	467,177.00
01-190-08	Чигжих шороог хийн тромбовкоор нягтруулах	М3	372.59	2.0/2	0.44/	163.71 6/	5212/5 212	853288	853,288.00
Ажиллах хүчний зардал									3,567,971.00
Орхигдуулсан буюу нэмэлт ажлын төсвийн газар шорооны ажлын тооцоо									
01-190-07	Чигжих шороог хийн тромбовкоор нягтруулах	М3	372.59	3.0/2	0.54/	201.72/	6150/5 212	124057 9	1,240,579.00
01-060-06	Хамар ханын суурийн нүхийг гараар ухах	М3	11.54	3.0/2	3.38/	39.023/	6150/5 212	239988 /	239,988.00
Ажиллах хүчний зардал									2,920,775.00

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв /Увс, Давст сум/-ын төсвийн тооцоо

2.5.3. Барилга байгууламжийн төсөвт өртгийг төлөвлөхдөө ажлын үе шат бүрээр тооцож нэг бүрчилсэн төсвийн тооцоог ашиглаж байгаагаас төсөл, арга хэмжээний төсөвт өртөг харилцан адилгүй тогтоогдож байна. Үүнд төсөвчний ур чадвар, ёс зүй, ажлын үндэслэл болон материалын үнийн сонголт нөлөөлж байна. Тухайлбал: Барилгын материалын 2022 оны үнийн жагсаалтаас зөвхөн хаалганы үнийг харьцуулахад дараах сонголтуудтай байна. Төсөвчин материалын үнийн жагсаалтаас хамгийн өндөр үнэтэйг сонгосон ч гүйцэтгэгч материалын сонголтыг хэрхэн хийсэн нь тэр бүр нотлогдох боломжгүй. Жишээлбэл:

Хүснэгт 6. Хаалганы үнэ /2022 оны 4 дүгээр сарын байдлаар/

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн цэвэр жин	Үнэ /2023 он/ /төгрөг/
1	Модон хаалга будаггүй /хуулгатай 2 хавтастай/	Ш	0.036	836,636.00
2	Модон хаалга будагтай 2 хавтастай	Ш	0.038	1,500,000.00
3	Металл хаалга	M2	0.025	557,345.00
4	Металл рамтай хаалга (гадна хаалга)	M2	0.045	503,159.00
5	Мөн хаалга тагтны FR-106	M2	0.030	236,836.00
6	Модон хаалга /шилтэй	M2	0.018	131,595.00
7	Вакум хаалга	M2		410,268.00
8	Металл хаалга /гадна хаалга/	M2	0.045	619,273.00
9	Хуванцар рамтай хаалга	M2	0.030	308,750.00
10	Тагтны хаалга FR-106	M2	0.030	208,945.00
11	Европ материалтай хуванцар хаалга	M2	0.032	379,245.00
12	Бүрэн тоногтой гадна хаалга	M2	0.035	557,345.00
13	Модон хаалга кропек нугастай	M2	0.025	238,373.00
14	Шилтэй модон хаалга кропек нугастай	M2	0.025	23,164.00
15	Резинин жийрэгтэй модон хаалга кропек нугастай	M2	0.025	275,482.00

Эх үүсвэр: 2022 оны барилгын материалын үнийн мэдээллээс

2.5.4. Барилга байгууламжийн зураг төслийн эх хувь зөвхөн зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчид хадгалагдаж, барилга байгууламжийг ашиглалтад орсны дараа Төрийн архивд хүлээлгэн өгч байгаа нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм”-ийн 7.1²³, 7.2²⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

Мөн магадлалаар баталгаажсан зураг, төсвийн тооцооны хуудас бүрийг тамга, тэмдгээр баталгаажуулахгүй байгаа нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад зураг төсөлд тусгагдаагүй, орхигдсон гэх үндэслэлээр төсөвт өртөг нэмэгдүүлэх залилангийн эрсдэлийг үүсгэх магадлалтай тул дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

БХБС-ын 2020 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 30 дугаар тушаалаар батлагдсан “Төсөв зохиох дүрэм”-д төсөвт өртгийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

2.9. Барилгын ажлын зураг төслийг боловсруулах шатанд хэрэглэгдэх төсвийн нормыг барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, томсгосон норм гэж ангилна.

2.16. Томсгосон норм, үнэлгээг төсвийн суурь нормыг үндэслэн боловсруулна.

3.1. Зураг төслийн баримт бичгийн бүрдэл хэсэг болох барилгын ажлын төсвийг томсгосон норм, үнэлгээ, төсвийн суурь нормыг үндэслэн боловсруулна. Томсгосон норм, үнэлгээг хэрэглэхдээ “Барилгын төсвийн томсгосон норм, жишиг үнэлгээ хэрэглэх дүрэм”-ийг баримтална.

3.6. Зураг төсөлд тусгагдсаны дагуу барилга байгууламжийн төсөвт өртгийг тодорхойлохдоо нэг бүрчилсэн төсөв, объектын төсөв, зардлын төрлийн төсвийн тооцоо, барилга байгууламжийн нэгдсэн төсөв гэсэн бүрэлдэхүүнтэйгээр төсвийн баримт бичгийг зохионо.

3.7. Нэг бүрчилсэн төсөв нь төсвийн анхан шатны баримт бичиг бөгөөд түүнийг ажлын зургийн дагуу тодорхойлсон ажлын тоо хэмжээг үндэслэн барилга байгууламж, талбайн

²³ Захиалагч магадлалын дүгнэлт, эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг цахим (PDF форматаар CD хэлбэрт хөрвүүлэх) хэлбэрээр, барилга байгууламжийн төсвийг цахим болон цаасан хэлбэрээр энэ дүрмийн 6.1-д заасан байгууллагын архивт зохих журмын дагуу хүргүүлнэ,

²⁴ Барилгын тухай хуулийн 25.5-д заасны дагуу зураг төсөлд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн хэсэгт хийгдсэн магадлалын дүгнэлтийг архивын эх материалд хавсаргана.

ажил, түүний үе шатаар зохионо. Жишээ нь. Барилгын ажил, халаалт салхивчийн ажил, гадна дулааны ажил гэх мэт. Нэг бүрчилсэн төсвийг төсвийн суурь норм, томсгосон нормыг үндэслэн зохионо гэж тусгажээ.

Барилга байгууламжийн нэг бүрчилсэн төсвийг санхүүжилтийн гүйцэтгэл гаргах, төсөвт өртгийн судалгаа хийх, компанийн дотоод тооцоо зэрэгт ашиглаж, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, гүйцэтгэгч шалгаруулах тендерийн үйл ажиллагаанд томсгосон төсөв ашиглах нь гүйцэтгэгч шалгарсны дараа “тендерийн ажлын тоо хэмжээ дутуу байсан” нэрээр төсөвт өртгийг нэмэгдүүлэх эрсдэлээс сэргийлэх боломжтой.

Тендерт оролцогч нь томсгосон норм үнэлгээгээр төлөвлөсний дагуу төсвийн тооцоог боловсруулж үнийн санал өгч оролцох, төсвийн тооцоонд алдаа гаргаснаас үүсэх эрсдэлийг өөрөө хариуцдаг тогтолцоог бий болгосноор хэт бага, үндэслэлгүй үнийн саналаар шалгарахыг хязгаарлаж, төсөвт өртгийн нэмэгдлийг зогсоох, чанаргүй барилга барих нэг нөхцөлийг арилгах боломжтой болно.

Дүрслэл 10. Барилга байгууламжийн төсөвт өртгийн задаргаа



- Тайланд тусгагдсан 1,617,352.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 313 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 823,514.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал ирүүлснийг 120,222.0 сая төгрөгөөр бууруулж 703,292.8 сая төгрөгөөр баталгаажууллаа.
- Тус 313 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг холбогдох байгууллагуудын магадлалын дүгнэлтээр 2,560,132.5 сая төгрөгөөр баталгаажуулсныг аудитаар 230,408.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 38 төсөл, арга хэмжээний төсвийн дүнг магадлалын дүнгээр, 1,386,943.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 275 төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлтийн дүнг 77,483.3 сая төгрөгөөр буурууллаа.
- Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүй, хэрэгжих явцад зураг төсөлд өөрчлөлт оруулсан зэргээс шалтгаалан төсөвт өртөг өсөж, улсын төсөвт ачаалал үүсгэж байна.
- Төсөл, арга хэмжээг төлөвлөх үе шатанд Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам жил бүр зөрчигдөж байгаа шалтгааныг тодруулан үүсэж байгаа үр дагаврыг арилгахад дэмжлэг үзүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлт хийх, хариуцлагын тогтолцоог өөрчлөх шаардлага үүссэн байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа магадлалаар баталгаажсан иж бүрэн зураг төсөлд үндэслэхгүй байгаа нь тендерт шалгарсан компанид давуу байдал бий болгож байна.
- Барилга байгууламжийн төсвийн анхан шатны баримт бичиг болох нэг бүрчилсэн төсвийн тооцоо, үе шатны ажлын тоо хэмжээнд үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа нь төсвийн тооцоонд ажлын тоо хэмжээ орхигдуулсан, дутуу тооцсон гэх асуудлаар төсөвт өртгийг нэмэгдүүлэх эрсдэлийг үүсгэж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, төсөвт өртгийн нэмэгдэл зардлын тооцоонд салбарын хяналт хэрэгжүүлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит хийгээгүй, алдаа зөрчлийг тухай бүр арилгаагүй байгаа нь хяналтын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.
- Барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн тооцоог гүйцэтгэж байгаа инженер, төсөвчин, экспертүүдийн ур чадварыг сайжруулах, магадлал хийх үйл ажиллагаанд өрсөлдөөнийг бий болгох шаардлагатай байна
- Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө барилга байгууламжийн нэг бүрчилсэн төсвийн тооцоог ашиглаж байгаа нь барилга байгууламжийн төсөвт өртгийг харилцан адилгүй төлөвлөх шалтгаан болж байна.
- Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцох, төлөвлөх, хэрэгжүүлэх үе шатанд ашиглах төсвийн тооцоо, норм нормативын баримт бичгийг шинэчлэх, эрх зүйн орчныг сайжруулах шаардлага үүссэн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд жишиг үнэ, үнийн индекс, томсгосон норм үнэлгээг хэрэглэх эрх зүйн орчныг бий болгох,

Монгол Улсын Ерөнхий сайдад:

Барилга байгууламжийн эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн норм, нормативын баримт бичгийг шинэчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцох, магадлал хийх тогтолцоог үнэлэх, төсөвт өртөг нэмэгдэх нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдэлийг удирдах;

Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд хяналт хийж, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг тооцож, иргэн, хуулийн этгээдийн магадлал хийх эрх олгох үйл ажиллагаанд тэгш өрсөлдөөнийг бий болгох;

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ийн тогтолцооны зохистой байдалд дүгнэлт гаргаж, шаардлагатай бол чиг үүргийн өөрчлөлтийг хийх,

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт дотоод аудитыг тогтмол хугацаанд гүйцэтгэж хэрэгжилтийг тайлагнадаг байх,

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал нарт:

Магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маяггүй, нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгахгүй байгаагаас захиалагч гүйцэтгэгч нарт ойлголтын зөрүү үүсэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд илүү, дутуу дүнгээр тусгах эрсдэлийг арилгаж, нэгдсэн загварт оруулж, баталгаажуулах



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НАРАНЧИМЭГ
ТАНАА

2023.12.07 № 0318945

танай _____-ны № _____-т

Тайлангийн төсөлд санал өгөх тухай

"Улсын төсвөөр санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж, баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал авах тухай Таны 01/2497 тоот албан бичигтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Үүнд:

1. Тайлангийн төсөлд үндэслэж буй хууль, журмын зохицуулалтыг буцааж хэрэглэхгүй байх талаар анхаарах;
2. Тайлангийн төслийн зөвлөмжийн "Монгол Улсын Их Хуралд топилуулах нь хэсгийн "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд жишиг үнэ, үнийн индекс, томсгосон норм үнэлгээг хэрэглэх эрх зүйн орчныг бий болгох" гэснийг "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөвт өртгийг тооцох жишиг үнэ, индексийн томсгосон норм үнэлгээг хэрэглэх эрх зүйн орчныг бий болгох" гэж өөрчлөн найруулах;
3. Тайлангийн төслийн зөвлөмжийн "Монгол Улсын Ерөнхий сайдад" хэсгийн "Барилга байгууламжийн эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн норм, нормативын баримт бичгийг шинэчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх" гэснийг "Барилга байгууламжийн эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн норм, нормативын баримт бичгийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх" гэж өөрчлөн найруулах.

Түүнчлэн дээрх тайлан, дүгнэлт нь төсвийн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хариуцлагыг бүрдүүлэх тогтолцоог сайжруулахад түлхэц үзүүлэхээр байх тул талархалтай байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766017562